

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025.04.25-ны өдрийн ээлжит хурлын
тэмдэглэл**

2025.04.25

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 25-ний өдрийн Баасан гаригт Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18135, товчооны зам гудамж, 59 тоот өөрийн байранд 10:00 цагт эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгон, Нягтлан бодогч О.Ганчимэг хурал зохион байгуулах комиссын гишүүн Н.Батнайрамдал, тооллогын комиссын дарга Ө.Энхтайван, гишүүн Л.Даваагэрэл, Г.Бадамдорж нар мөн нийт 2 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар, 3 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр оролцов.

Хурлын дарга Ш.Амар-отгон: Сайн байцгаана уу. Та бүхэнд өглөөний мэнд хүргье. “Хай Би Ойл” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа

Ингээд “Хай Би Ойл” ХК-ийн 2025 оны 04 сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулья. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 88,98% буюу 46,377,976 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдсэн тул хуралаа эхлэж байна.

Өнөөдрийн хурлыг “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон миний бие даргалах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэг, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлийг өгнө.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах
4. Энэ жилийн ногдол ашгийн талаарх гаргасан ТУЗ-ын шийдвэрийг танилцуулна.

Миний бие “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захиралаар 6 дахь жилдээ ажиллаж байгаа Ш.Амар-Отгон гэж хүн байна. Та бүхэнд хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал тараасан байгаа та бүхэн танилцаарай. Бид 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулна. Би үйл ажиллагааныхаа тайланг ерөнхийд нь танилцуулна. Манай нягтлан бодогч О.Ганчимэг санхүүгийн тайлан, аудитын тайланг танилцуулах болно.

“Хай Би Ойл” ХК-ний үйл ажиллагааны тайланг танилцуулья. Бид өнгөрсөн 2024 онд ачаалал ихтэй, үр өгөөжтэй, маш ажилласан гэж харж байгаа. Хай Би Ойл ХК нь нийт 9 ажилтантай ажиллаж байгаа, үүнд Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, менежер, харуул, үйлдвэрийн дарга, ахлах оператор, туслах 2 оператор, ТУЗ нарийн бичгийн дарга гэсэн

бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Бид 2024 оны 04-р сарын 01-ны өдрөөс ажиллаж эхэлсэн. Үйлдвэрлэл борлуултын тухайд бол манай компани 2024 онд ажилласан 7 сарынхаа хугацаанд нийт 33-н аж ахуй нэгжтэй техникийн хаягдал тос цуглуулах гэрээ байгуулсаны дагуу нийт 1,144,500 литр техникийн ашигласан хаягдал тос цуглуулж, 852,950 тонн мазут боловсруулан 5 аж ахуйн нэгжид мазутаа борлуулсан байна. Өөр бусад ажил үйлчилгээ авахаар 4 газартай гэрээ байгуулж ажилжээ.

2024 оны 4 сар эхлээд Байгаль орчины яам болон Уул уурхайн яам, Стандарт хэмжилзүйн газар, Нийслэлийн мэргэжилийн хяналтын газар зэрэг газруудаас ээлж дараатай шалгалтууд хийгдсэн бөгөөд шалгалтаар хугацаатай болон хийх ажлуудын даалгаварууд өгсөнийг цаг тухай бүрд нь биелүүлэн ажилласан. Үүний нэг нь нийт 27 м3 талбай болох Үйлдэрт болон түүхий эд цуглуулах хадгалах агуулах, үйлдвэрийн байр, оффис, газар доорх агуулах, нүхэн жорлон, зэрэг хөрсийг хаягдал тос буулгах цэгийн хөрсийг хамгаалах үүднээс бохирдсон хөрсийг цэвэрлэж, бетондож, хөрсний бохирдсон хэсгийн хорыг саармагжуулах ажил хийгдсэн. Мөн Үйлдвэр доторх агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах газрын гадаргаас тоос тоосонцор агаарт дэгдэх магадлал өндөр, тоосжилтыг дарах, үйлдвэрийн зохион байгуулалтыг сайжруулахын тулд үйлдвэр доторх цементен шалыг резнин будгаар будуулж сайжруулсан. Мөн хот дотор явж тосоо цуглуулдаг тээврийн хэрэгсэлүүдэдээ авто тээврийн газраас холбогдох зөвшөөрөлүүдийг авсан. Ажилчидаа Сонгдо эмнэлэг дээр жил бүр эмчийн үзлэгт хамруулдаг бөгөөд энэ жил мөн эрүүл мэндийн үзлэгтээ хамрагдсан. Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд компанийн зүгээс мод тарьсан, тус модоо 61-ын граммын ойролцоо инчон төгөлд хамт олоноороо нэг өдөр явж, 336 ширхэг шинэс мод тариалаад ирсэн.

“Хай Би Ойл” ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаад “Эвиденсе” ХХК-аар аудит хийлгэсэн. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангын талаар нягтлан бодогч О.Ганчимэг танилцуулна.

“Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг: “Хай Би Ойл” ХК-ийн нягтлан бодогч О.Ганчимэг байна. Хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. 2024 оны тайлангийн үзүүлэлтүүдийг танилцуулий.

Санхүүгийн байдлын үзүүлэлт:

2024 оны 4-р улиралд нийт хөрөнгийн дүн 5,217.8 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 15,7% буюу 825,6 сая төгрөг, эргэлийн бус хөрөнгө 84,3% буюу 4,392.2 сая төгрөг байна.

Нийт эх үүсвэр 5,217.8 сая төгрөг, үүнээс өр төлбөр нь 203.1 сая төгрөг, эзний өмч 5,014,7 сая төгрөг байна

Орлогын тайлан:

2024 оны нийт орлого 1,392.7 сая төгрөгийн орлоготой 130,8 төгрөгийн зардал, 14.8 төгрөгийн бусад зардал, 521,4 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Өмчийн өөрчлөлтийн тайлан:

2024 онд ашигтай ажиллаж 4-р улиралын эцэст эзний өмчийн дүн 5,014.7 сая төгрөг байна

Мөнгөн гүйлгээний тайлан:

2024 оны 4-р улиралд мөнгөн орлого 1,409.5 сая төгрөг, зарлага нь 1,018.3 сая төгрөг, үйл ажиллагааны гүйлгээ 391,3 сая төгрөг, улиралын эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 351,1 сая төгрөг

“Хай Би Ойл” ХК нь 2024 онд татварын дараах ашиг нь 521,4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Хэдийгээр компани 521,4 сая төгрөгийн ашигтай ажилласан ч ногдол ашиг тараах боломжгүй байсан. Тухайн ашигаараа бид 2025 оныхоо ажлын эргэлтийн хөрөнгөнд ашиглах ёстой үүнд ажилчидын цалин түүхий эд цуглуулах тээврийн зардал гэх мэт байна. Дансны авлага 354 сая төгрөг байгаа бид мазутаа зээлээр борлуулалт хийдэг. Ер нь бүтээгдэхүүнээ бэлэн мөнгөөр борлуулах боломж маш бага ихэнх тохиолдолд бартер болон зээлээр худалдан авах л хүсэлтэй байдаг. Зээлээр худалдсан мазутынхаа төлбөрийг одоо хүртэл авч чадаагүй байна. Татварт аж ажуй нэгжийн орлогын албан татварын өглөгтэй байгаа. Энэ жил аудит дүгнэлт хязгаарлалттай гэсэн үнэлгээтэй гарсан.

2024 онд түүхий эдийн хомсдол үүсч дандаа худалдаж авч цуглуулсан. Мөн тог цахилгааны үнэ нэмэгдсэн, манай үйлдвэр 100 хувь тоогоор ажилдаг.

Гүйцэтгэх захирал Ногдол ашгийн тухайд: ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэрийг танилцуулья аа. Компанийн 2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэлээр ашигтай ажилсан ч энэ нь компанийн 2025 оны ажлын эхний эргэлтийн хөрөнгөд зарцуулагдахаар байгаа, хэдийгээр ашигтай ажилласан гэж харагдаж байгаа ч дансанд байгаа бэлэн мөнгө нь бага, авах авлагууд байгаа бөгөөд зарим нь шүүхийн шатанд явж байна. Түүхий эдийн үнэ энэ жил маш их өссөн буюу 750-850 төгрөг болсон тул бид байгаа хэдэн төгрөгөөрөө түүхий эд авах, ажилчидынхаа цалинг тавих, бусад зардалд зарцуулах шаардлагатай байгаа тул ногдол ашиг тараах боломжгүй гэж үзээд ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэр гарсан байгаа шүү.

Компанийн үйл ажиллагаа улиралын чанартай буюу яг идэвхитэй ажилдаг 7 сар л байдаг үлдсэн 5 сард нь сул зогсдог, 7 сардаа хийсэн ажлын борлуулалт нь тухайн жилийнхээ зардал болон ирэх жилийн ажиллах эргэлтийн хөрөнгөндөө зарцуулагдаал түүнээсээ илүү гарахгүй л байна. Бид боловсруулсан бүтээгдэхүүнээ 900 төгрөгөөр зардаг, энэ жил тог цахилгаан, түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулаад бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэхээр төлөвлөж байна.

Уг нь хаягдал тосыг тусгай зөвшөөрөлтэй газруудад нийлүүл гэж авто засварын газруудад холбогдох төрийн байгууллагуудаас шаардлага тавьдагч дийлэнхи газрууд манайхтай гэрээ байгуулчаад гэрээнийхээ дагуу нийлүүлэхгүй, тусгай зөвшөөрөлгүй, жижиглэнгээр авдаг хүмүүст арай өндөр үнээр зараад байгаа асуудалууд гарч байгаа. Хаягдал тосыг боловсруулахгүйгээр гар аргаар шатаагаад байгаа хүмүүс бас байна.

Хувьцаа эзэмшигч: Ж.Энхтунгалаг: Тэгвэл гэрээнийхээ заалтанд тэгсэн тохиолдолд цуцлана гэдэг ч юмуу заалт оруулж болохгүй юу.

Гүйцэтгэх захирал: Гэрээг цуцлана гэсэн заалт байдаг

Хувьцаа эзэмшигч: Ж.Энхтунгалаг: Шарын гол ХК-ийн хувьцаа эзэмшдэг гэж байна хэдэн хувийг эзэмшдэг вэ.

Н.Батнайрамдал: 18,1 хувийг нь эзэмшдэг. Манай компанийн хувьцаа энэ жил 48 төгрөг хүрч өссөн. Ноднин 25 төгрөг байсан.

Хурлын төгсгөлд хурлын дарга Ш.Амар-отгон тооллогын гишүүдээс ирсэн санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 88,98 % буюу 46,377,976 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 88,98 % буюу 100% хүчинтэй байлаа.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.
2. Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс Б.Батбаатар 11,1%, Б.Дөлгөөнтамир 11,1%, С.Одгэрэл 11,1%, У.Энхбилэг 11,1%, Р.Оюунбат 11,1% Ш.Амар-Отгон 11,1-ийн санал авч ердийн гишүүдэд сонгогдлоо.
Хараат бус гишүүдэд Б.Гэрэлтуяа 11,1%, Т.Тамир 11,1%, Г.Бадамдорж 11,1%-ийн саналтайгаар сонгогдлоо.
3. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны хуралд маань цаг заваа гарган оролцсон та бүхэндээ баярлалаа.

Хурал 11:00 дуусав.

ХУРЛЫН ДАРГА:

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Ш.АМАР-ОТГОН

Н.БАТНАЙРАМДАЛ